

“Ус хагалбарын цэг Хөндлөн уул”-ыг улсын тусгай хамгаалалтанд авах асуудал

Нармандах. Ч¹, Атутова.Н.А², Амарбаясгалан. Ё³.
1ОХУ-ын ШУА-ын Геологийн хүрээлэнгийн докторант,
2ОХУ-ын Газарзүйн нийгэмлэгийн гишүүн,
3Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, ШУА, ЭШДА, магистр
e-mail: chnarmandakh@yahoo.com

Хураангуй:

Дэлхий дээр ач холбогдол бүхий дөрвөн том ус хагалбарын цэг байдаг. Тэдгээрийн нэг нь Монгол улсын нутагт байдаг. Дэлхийн улс орнууд усны нөөцийн хомсдлоос сэргийлэх олон арга, зарчмыг хэрэгжүүлж байгаа. Түүний нэг жишээ нь ус хагалбарын цэг оршиж буй улс орнууд тухайн газар нутгийг улсын тусгай хамгаалалтандаа авсан байна. Үүний нэгэн адил манай улс Хойд мөсөн далай, Номхон далай, Төв Азийн гадагш урсацгүй ай савын ус хагалбарын шугамын огтлолын цэг болох Хэнтийн нурууны үргэлжлэл Цогтчандмань уулын баруун салбар Хөндлөн уулыг улсын тусгай хамгаалалтанд авах шаардлагатай юм.

Abstract:

There are four big important watershed points in the world. One of the biggest watershed point is located in the Mongolian territory. Many countries in the world try to prevent depletion of water resource deficit. For this, some countries with the watershed points that have been declared state special protected area. Similarly, in our country has to make protection for Arctic Ocean, the Pacific and Central Asian Internal Drainage Basin watershed line intersection, which is located in the Khundlun Mountain in the Khentii Range.

Түлхүүр үг: Ус хагалбарын цэг, усны нөөц, тусгай хамгаалалт.

I. ОРШИЛ

Манай гарагийн аль ч улс орны, ард түмэн усыг өдөр тутам, янз бүрийн байдлаар хэрэглэдэг нь туйлын үнэн билээ. Хүн төрөлхтөний амьдралд голын сав газрууд чухал үүрэг гүйцэтгэсээр өдгөөг хүрсэн байна. /Ус хурах талбай ба гол, горхи, нуурыг усаар тэтгэх ул хөрс, газрын гүний уст үе давхаргыг хамтад нь сав газар ба ай сав хэмээн нэрлэдэг. Тив, эх газрын хэмжээнд ай сав, тухайн улс орны хэмжээнд сав газар хэмээн ялгаж үздэг/. Уур амьсгалын өөрчлөлт, хүний зүй зохисгүй хэрэглээ ашиглалт зэргээс үүдэн голын сав газрын экосистем алдралд орж усны нөөц жилээс жилд

хомсдох болсон. Тиймээс бид оршин амьдрахуйн үндэс болсон цэвэр усны нөөцийн эх үүсвэр /ус хагалбарын цэг/ түүний ойр орчмын газар нутгийг хамгаалан улсын тусгай хамгаалалтанд авснаар усны нөөцийн хомсдлоос сэргийлэх асуудалд чухал ач холбогдолтой юм.

II. СУДАЛГААНЫ АРГАЗҮЙ, ЗОРИЛГО

Өмнөх судлаачдын судалгааны материалыг судлан, ус хагалбарын цэгүүд хаана ямар улс орнуудад байдгийг хамтарсан судалгаагаар тодорхойлон, Arc GIS программ ашиглан зураглаж усны нөөцийн хомсдлоос сэргийлэх асуудалд санал дэвшүүлэх зорилгоор энэхүү судалгааны ажлыг бичсэн.

III. СУДАЛГААНЫ ҮР ДҮН БА ХЭЛЭЛЦЭМЖ


Дэлхий дээр ач холбогдол бүхий дөрвөн ус хагалбарын цэг байдаг байна. Үүнд:

1. Хойд мөсөн далайн ай сав, Номхон далайн ай сав, Төв азийн гадагш урсацгүй ай савуудын ус хагалбарын цэг буюу дэлхийн цэвэр усны нөөцийн гурван ай савын огтлолцлын цэг Хэнтийн нурууны салбар Цогтчандмань уулын баруун салбар “Хөндлөн” уул, Монгол улс.
2. Хойд мөсөн далайн ай сав, Номхон далайн ай сав буюу Лен, Енисей, Амур мөрний ус хагалбарын цэг “Гора Палласа” уул Оросын холбооны улс.
3. Хойд мөсөн далайн ай сав, Номхон далайн ай сав, Атлантын далайн ай сав буюу Миссисипи, Колумбия, Нельсон голуудын ус хагалбарын цэг Хойд Америк-Канадын хил дээр “Triple Divide Peak” уул, Америкийн Нэгдсэн улс-Канадын хил дээр.
4. Дэлхийн хамгийн өндөрт орших ус хагалбарын цэг нь Ганга, Инди,

Брахмапутра мөрний ус хагалбарын цэг,
Төвдийн тэгш өндөрлөг, Хятад улс.

1. Цогтчандмань уулын баруун салбар “Хөндлөн уул” ус хагалбарын цэг

Дэлхийн цэвэр усны гурван ай савын огтлолцлын цэг болох Хэнтийн нурууны салбар Цогтчандмань уулын баруун салбар болох Хөндлөн уулыг БНМАУ-н Усны аж ахуйн яамны харъяа Усны хайгуул төсөл, эрдэм шинжилгээний институт (хуучин нэрээр), БНУУ-ын Усны институттай хамтарсан судалгааны үр дүнд 1971-1975 онд тус ус хагалбарын цэгийг тодорхойлсон байна. 1990 онд дээрх институтын эрдэмтэд, судлаачдын санаачилгаар энэхүү ус хагалбарын шугамын огтлолцлын цэгийг илүү нарийвчлалтайгаар тодорхойлох ажил өрнөж Геодези зураг зүйн газар, Газарзүй-Цэвдэг судлалын хүрээлэн (хуучин нэрээр) хамтран ажиллажээ. Энэ ажлын үр дүнд дэлхийн ус хагалбарын гурван том ай савын ус хагалбарын шугамын огтлолцлын цэг нь Төв аймгийн Эрдэнэ сумын нутагт орших “Хөндлөн уул” хойд өргөргийн $47^{\circ} 39' 07''$, зүүн уртрагийн $107^{\circ} 31' 28''$ солбилцолд далайн түвшнээс дээш 1854.5 метрт орших цэг мөн гэж тодорхойлжээ. Энэ ажлыг профессор Ц. Балдандорж нарийвчлан судлах саналыг дэвшүүлэн, удирдан ажиллаж тус цэгийг тодохойлон тус цэг дээр 3 тал бүхий хөшөө барисан байна (зураг 1,2).



Зураг 1. Ус хагалбарын цэгийн газарзүйн байршил.



Зураг 2. Хөндлөн уулын орой дээр барьсан 3 талт хөшөө.

Хаврын улирал болж Хөндлөн уулын оройд унасан цас хайлах, зун, намартаа бороо ороход ус нь гурван зүг рүү урсан нэвчиж, зүүн, зүүн урд хажуугийн ус нь Хэрлэн голыг тэжээн Номхон далайн ай савд (Онон, Улз, Халхын гол г.м), хойд, хойд хажуу руу урсаж нэвчсэн ус нь Туул голыг тэжээн Хойд мөсөн далайн ай савд цутгадаг (Орхон, Сэлэнгэ г.м). Харин баруун урд тал руу урсаж нэвчсэн ус нь Төв азийн гадагшаа урсгалгүй ай савын гол мөрдийг тэжээдэг (Ховд, Байдраг, Завхан г.м) байна.

2. “Гора Палласа”-ын ус хагалбарын цэг

Энэ цэгийг анх Тимур Жалсарайн 1977 онд нээсэн байна. Лень, Енисей, Амур мөрнүүд нь дэлхийн арван таван их мөрөнд багтдаг. Энэ гурван мөрний ус хагалбарын цэг нь ОХУ-ын Чита мужаас баруун хойд зүгт хойд өргөргийн 52.0 , баруун уртрагийн 113.5 градусын солбилцолд байдаг бөгөөд уулзварыг “Палласа” уул гэж нэрэлсэн. Бороо ороход Палласа уулын оройгоос ус нь гурван тийш урсаж хойд зүгт урссан ус нь Витим голоор дамжин Лень мөрний ай сав руу, баруун тийш урссан ус нь Хилок голоор дамжин Енисей мөрний ай сав руу, зүүн тийш урссан ус нь Ингода голоор дамжин Амур мөрний ай савд цутгадаг. Ус хагалбарын цэг Паласа уулын газарзүйн байршил болон тус уулын орой дээрх таних тэмдгийг (зураг 3,4) д үзүүлэв.



Зураг 3. Палласын байршил ба цэг дээрх тэмдэг.



Зураг 5. Андомскийн өндөрлөг дээрх тэмдэг.




Зураг 4. Палласын байршил газрын зураг дээр.

Оросын газар нутгийн европын хэсгийн хамгийн их судлагдсан байгалийн объект нь Андомын өндөрлөг газрын цэг юм. Карелийн эрдэмтдийн судалгаагаар Андомын өндөрлөг газар дээр европын гурван их ай сав уулздаг. Тэрээр тус цэгээ “Атлека” гэж нэрэлсэн бөгөөд энэ нь Атлантический-Ледовитого ба Каспийский гэсэн үгнүүдийн эхний хоёр үсгийн нийлбэр юм. Үүнд: Балтийн (Андома, Коломба ба Сомба голуудын цутгал), Беломорскийн (Тихманьга ба Ухта голуудын цутгал), Каспийн (Сойда ба Кема голуудын цутгал) багтдаг. Геологич проф. Вячеслав Куликов 1990 онд Андомскийн өндөрлөг газарт Атлантын далай, Хойд мөсөн далай, Каспийн тэнгисийн ай савын ус хагалбарын цэгийг тогтоосон. 1997 онд экспедиц ажиллаж тухайн цэг дээр тэмдэг тавьжээ (зураг 5).

3. АНУ-Канадын “Triple Divide Peak” ус хагалбарын цэг

Хойд Америк-Канадын хил дээр (хойд өргөргийн 48.5, баруун уртрагийн 113.5 градус)-д “Triple Divide Peak” ус хагалбарын цэг оршдог бөгөөд тус цэг нь Номхон далай, Хойд мөсөн далай, Атлантын далайн буюу Миссипи, Колумбия, Нельсон голуудын хагалбарын цэг юм (зураг 6,7). Энэ цэгийг Америк тивийн уугуул иргэд болох Индианчууд ихэд хүндэтгэдэг төдийгүй хамгаалдаг байжээ.




Зураг 6. Америк, Канадын ус хагалбарын цэг.

өргөрөгийн 30° 20' 40.4", зүүн уртрагийн 82° 01' 19.9" оршино. (Р.А.Филенко). Төвдийн өндөрлөгөөс Меконго, Янцзы ба Салуина голууд эх авч урсдаг азийн гурван их мөрний ус хагалбарын цэг байдаг.



Зураг 7..Triple Divide Peak-н байршил.




Зураг 9. Ганга, Инди, Брахмапутра мөрнүүдийн ай савын схем.

Өнөөдөр “Triple Divide Peak”-ыг улсын хамгаалалтанд авсан төдийгүй аялал зуулчлалын томоохон бүс болгожээ. 2015 оны байдлаар энд хамгийн орчин үеийн үндэсний том "GLACIER NATIONAL PARK" ажиллаж байна (зураг 8).



Зураг 8. Triple Divide Peak-д байгуулсан үндэсний аялал зуулчлалын хүрээлэнгийн самбар.



Зураг 10. Ганга, Инди, Брахмапутра мөрнүүдийн схем.

4. Ганга, Инди, Брахмапутра мөрний ус хагалбарын цэг

Энэ цэг нь дэлхийн хамгийн өндөрт орших ус хагалбарын цэг бөгөөд Гимлайн нуруунд далайн түвшнээс дээш 6150 метрт оршдог. Хойд

IV. ДҮГНЭЛТ

Хэнтий нурууны үргэлжлэл Цогтчандмань уулын баруун салбар Хөндлөн уул, Ябловны нуруунд байрлах Палласа уулууд нь нэршилийн хувьд өөр боловч уул зүйн тогтоцоороо нэг нуруунд байрладаг. Гэхдээ Цогтчандмань уулын баруун салбар Хөндлөн уул нь хойд мөсөн далай, номхон далай, төв азийн гадагшаа урсгалгүй ай савуудыг зааглан оршдог бол Палласа уул нь Лень, Енисей, Амур мөрнүүдийн ай савуудын ус хагалбарын цэг болж байгаач том ай саваар нь авч үзвэл үндсэндээ

хойд мөсөн далай, номхон далайн гэсэн хоёр ай савыг зааглаж байна.

Хойд Америк тивд орших “Triple Divide Peak”, Ази тивд орших Палласа уул нь дэлхийн хоёр талд “Палласа” уул (хойд өргөргийн 52, баруун уртрагийн 113.5 градус)- Triple Divide Peak” (хойд өргөргийн 48.5, баруун уртрагийн 113.5 градус)-д буюу дэлхийн бөмбөрцөгийн голчтой симметрлэг байна.

Дэлхийн ус хагалбарын цэгүүд Ази, Америк, Европ тивд оршиж, дэлхийн улс орнууд геополитекийн түвшинд АНУ, Канад, Орос, Хятад, Монгол зэрэг 5 улсын харъяалалд багтаж байна. Гэхдээ АНУ, Канад улс “Triple Divide Peak”-д үндэсний цэцэрлэгт хүрээлэн болгож улсын тусгай хамгаалалтанд авсан байна.

Атлека ус хагалбарын цэг Вишерском дархан цаазтай газарт харъяалагдаж байна. Мөн Палласа уулыг аялал зуулчлалын, үндэсний цэцэрлэгт хүрээлэн болгохоор 2013 оноос Оросын газарзүйн нийгэмлэгийн судалаачид судалгааны ажлыг эхлүүлээд байна.

Азийн гурван эх мөрний ай савыг Хятадын засгийн газраас 2000 онд хамгаалж дархан цаазтай болгож Саньцзяньюань гэж нэрэлжээ.

Тэгвэл Монгол улсын нутагт байрлах Дэлхийн цэвэр усны гурван ай савын хагалбарын цэг болох

орших боловч нэгэн сонирхолтой зүй тогтол байна. Энэ бол газарзүйн солбилцол нь бараг адил юм.

Цогтчандмань уулын баруун салбар Хөндлөн уулын экосистемийг хамгаалах, улсын тусгай хамгаалалтанд авах, дэлхийд сурталчилах шаардлагатай юм.

Ашигласан бүтээлийн жагсаалт

- [1] Международна научна практична конференция. IX, Въдешето въпроси от света на науката. 2013 он.
- [2] Филенко Р.А., Атутова Н.А., Нармандах Ч. г.София Екология, География и геология. “об открытий тройных водораздельных стыков: история, анализ, охрана, Том-31 [с.72]. 2013 он.
- [3] Филенко Р.А., Атутова Н.А., Нармандах Ч. Окружающая среда и устойчивое развитие Монгольского плато и сопредельных территорий. Том-1 “Водораздельные точки Забайкалья и Монголии” ”. [с.126]. г.Улан-Удэ, 2013 он.
- [4] Г.Долгорсүрэн “Усны нөөц болон экологи, эдийн засгийн үнэлгээ хийх аргазүйн гарын авлага”, 2012 он.
- [5] Ж.Бямба. Монголын геологи ба ашигт малтмал. Гидрогеологи. VIII боть. 2012 он.